



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 14 өдөр

Дугаар A/396

Улаанбаатар хот

**Халдварт өвчний дархлаажуулалт,
ариутгалын арга хэмжээг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4, 9.5, 9.6, 9.7, Нийслэлийн засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 02-ний А/1321 дугаар Мал эмнэлгийн арга хэмжээ зохион байгуулах тухай захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/99 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б. Номин)-т үүрэг болгосугай.

2.Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулж, тайлан мэдээг тухай бүр ирүүлж ажиллахыг дүүргийн мал эмнэлэг, үйлчилгээний “Сод Хан” ХХК (Д.Баасанхүү)-д даалгасугай.

3.Дээрх ажилд шаардагдах зардлыг хавсралтаар баталж Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ



1525012233